

МИЛЛЕР БА ХЯТАД, ОРОС, МОНГОЛ ГУРВАН ЭТГЭЭДИЙН ГЭРЭЭ

О.БАТСАЙХАН

1914 –1915 оныг дамжин бүтэн 9 сар үргэлжилсэн гурван улсын Хиагтын хэлэлцээр нь ХХ зууны Монгол улсын тусгаар тогтнолын тухай асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй байсан хэмээхийг тэмдэглэвэл зохино.

Монгол Улсын Олноо өргөгдсөний тавдугаар оны зуны тэргүүн сарын 25-нд Хиагт хотноо “тогтоосон” Хятад, Орос, Монгол гурван этгээдийн гэрээ бичгийн нэгдүгээр зүйлд “Гадаад Монголоос Думдад Иргэн улсын хоёрдугаар он 11 дүгээр сарын 5, Орос улсын 1913 он Октябрь сарын 23-ны өдрийн Дундад, Орос Улсын илтгэн гаргасан бичиг ба Дундад, Орос хоёр улсын солилцсон мэдтүгэй хэмээсэн бичгийг зөвшөөрөн хүлээв”³⁶ хэмээн заасан байна.

Илтгэн гаргасан бичиг ба Мэдтүгэй хэмээсэн бичиг гарч ирсний учрыг түүхийн хуудаснаас мөшгин үзэх аваас 1911 оны монголын үндэсний хувьсгалын дүнд сэргээн босгосон Богд тэргүүтэй Монгол улсын тусгаар тогтнолын асуудал руу хөтлөх вий.

“Богдыг Монгол Улсын наран гэрэлт, түмэн наст Богд эзэн хаан, Цагаан дар эхийг Улсын Эх дагина хэмээн өргөмжлөн, эрдэнийн сууринд залж суулгаад, оны цолыг Олноо өргөгдсөн, Их Хүрээг Нийслэл Хүрээ хэмээн нэрлэсэн, дундаа соёмбо үсэгтэй шар торгоор хийсэн төрийн далбаа бүхий Монголын тулгар төр нээсэн тухай”³⁷ даяар олноо тунхаглан зарласан 1911 оны (Олноо Өргөгдсөний тэргүүн он Өвлийн тэргүүн сарын шинийн есөн) тэр л өдрөөс эхлэн Богд тэргүүтэй Монгол Улсын Засгийн газар туурга, тусгаар улсаа төвхнүүлэн эмхлүүлж, тив дэлхийн улс гүрнүүдээр тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхийг эрмэлзэж байв.

Хэдийгээр 1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо зарласан хэдий ч түүнийг тууштай хүлээн зөвшөөрч, жижигхэн Монголын талд баттай байсан орон олон байгаагүй. Иймээс үнэн чанартаа Монголын тусгаар тогтнол тун хэврэг, олон улс гүрнээр баталгаажаагүй шахам байсан юм.

Иймээс Монгол улсынхаа тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх үүднээс Монгол Улсын Гадаад явдлын яамны сайд Чин

³⁵ О.Батсайхан - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

³⁶ Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (Өдөр тутмын тэмдэглэл)

Баримт бичгийн эмхтгэл УБ., 1999., 538 - 539 дэх тал

³⁷ Үндэсний төв архив. Түүхийн баримтын төв. ф.А-4, т.1, х.н.26, х.3

ван Ханддорж тэргүүтэй төлөөлөгчдийг 1912 онд, Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчдийг 1913 онд удаа дараа Хаант Орос улсад илгээн, Монголын тусгаар тогтнолыг бүрэн хүлээн зөвшөөрч, түүнд Барга, Дотоод Монголыг хамааруулах, санхүүгийн зээллэг олгох, зэвсэг худалдаалах, Петербург дэх гадаадын элчин нартай уулзуулж хэлэлцээ хийх зэрэг асуудлуудыг тавьж байсан байна.

1912 онд Орос Монгол хоёр улсын хооронд Найрамдлын гэрээ бичиг хэлэлцэн тогтоож, хоёр улсын хооронд гэрээ хэлэлцээр байгуулсан явдал бол Хаант Оросоос **“Монгол Улсын өөрөө эзэрхэх эрх ба нийт бүхнээ өргөмжлөгдсөн хаан эзэн, үүний засгийн газрыг давхар баталсан”**³⁸ хэрэг болсон юм. Энэ нь монголчуудын хувьд том дэмжлэг байлаа.

“Монгол Улс буурай, түүний хүн ард хоцрогдмол хэмээн бусдад ухуулж, Халх бол биеэ даасан улсын бүхий л хэргийг хөтлөн жолоодоход түүхийн хувьд бэлтгэгдээгүй юм”³⁹ хэмээн Хаант Оросын Гадаад явдлын яамны сайд Сазанов айлдаж байжээ. Энэхүү Сазанов 1912 оны 4 дүгээр сарын 12-нд Улсын Думийн хуралдаан дээр ярихдаа: **“Халх, Хятадыг хооронд нь бүрмөсөн зааглан салгах явдал нь биднийг нэг бол Монголыг эзлэн авах, үгүй бол тэндээс зайлж хятадуудад байлдан дагуулагчийн эрх олгон Монгол руу оруулах уу гэдэг замын өмнө тавихад хүргэнэ....** бид тэрхүү замаас зайлсхийхийг хичээж, хятад, монголчуудын хооронд зуучлагч болохыг зөвшөөрөв...” гэсэн нь Хаант Оросоос Монголын талаар тухайн үед баримталж байсан “монголчуудыг тэдний эзэн - Чин овгийн хаадаас нь салган тусгаарлахгүй байлгах” хэмээсэн бодлогын илрэл байв.

Хаант Оросоос Монголын талаар баримталж байсан бодлогыг Нийслэл хүрээний Орос консул Лавдовскийгоос Бээжин дэх Орос элчин Коростовецэд илгээсэн цахилгаанаас ч харж болно. Лавдовский бичихдээ “... Хэрэв бид монголчуудыг “асрахаа” татгалзах аваас, өөр нэг их гүрэн Монгол дахь бидний байр суурь эзлэх нь болзошгүй юм” гэсэн бий. Тиймээ, Хаант Орос улсаас Монголын талаар баримталсан энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд голлох үүрэгтэй оролцсон хүмүүсийн нэг бол оросын дипломатч А.Я.Миллер байв.

Тэрээр Гурван этгээдийн хэлэлцээрт Оросын засгийн газрын бүрэн эрх баригч, төлөөлөгчдийн тэргүүнээр оролцжээ. Бухар, Тегеранд орчуулагчаар, Ливерпул, Астрабад, Тавризид Хаант Орос улсын консулаар сууж байсан. 1913 оны 8 дугаар сарын 1-нээс 1915 оны 7 дугаар сард Монгол улсад Хаант Орос улсын ерөнхий консул бөгөөд дипломат төлөөлөгчөөр ажиллаж байхдаа Хиагтын гурван

³⁸ Үндэсний төв архив. ф.А-4, т.1, х.н.6, х.4

³⁹ Известия МИД кн. 3, с. 82, 1912 г.

этгээдийн хэлэлцээрт Хаант Оросын төлөөлөгчдийг тэргүүлж оролцсон. Түүний тухай А.В.Бурдуков өөрийн дурсамждаа: “Тэр үед А.Я.Миллер Хиагтад янзтай сонин хятад байшин бүхий худалдаачин Лушниковын сууж байв. Лушниковын уудам хашаа, тоглоом шиг жижигхэн хятад байшин, хүчирхэг их оросын төлөөлөгч Александр Яковлевич Миллер зэргийг би одоо тод санаж байна. Миллерийн энгийн байдал, зочломтгой чанар, Монгол дахь бидний ажил, амьдралын тухай ярианд анхааралтай хандаж байгаа нь Монголын зэлүүд тал нутгаас ирсэн, худалдааны жирийн ажилчин надад сайхан сэтгэгдэл төрүүлсэн юм. Энэ удаад энэ хүн намайг хуучин танилын хувьд баяртай хүлээн авав. Хэлэлцээрт тохиолдож буй янз бүрийн бэрхшээлийн тухай, монголчууд ер буулт хийдэггүй зантай, хятадууд цөхрөлтгүй оролдлого тавьдаг тухай тааламжтай энгийн байдлаар яриу. Монгол хэл мэдэхгүйдээ гаслан, хэрэв мэдлэгсэн бол монголчуудтай орчуулагч, завсрын хүнгүйгээр амархан тохиролцож болно гэж яриу” хэмээн ярьжээ.⁴⁰

Японы иргэн Кодاما 1913 оны 9 дүгээр сард Хүрээнд ирэхдээ Оросын ерөнхий консул А.Миллертэй нэг бус удаа уулзсан байдаг бөгөөд өөрийн тэмдэглэлдээ түүний талаар: Гэрийн эзэн ноён Миллер урьд Лондон хотноо гурван жил суусан, англиар сайн ярьдаг хүн санж. Бид оройн зоог дээр англиар бага сага ярьдаг нарийн бичгийн даргатай цуг гурвуул байлаа. Ноён Миллер консулынхаа байранд ганцаараа суудаг байсан тул надтай анх уулзахдаа Хүрээнд байх зуураа өөртэйгээ цуг байж болно гэж ярьсан билээ.

... Би ноён Миллер Гадаад явдлын яамны нарийн бичгийн даргын тушаалд дэвшсэнийг сониноос мэдсэнээ түүнд хэлэхэд тэрбээр энэ талаар цахилгаан утас наймдугаар сард авсан гэж хариулав хэмээн бичжээ.⁴¹

Гурван улсын хэлэлцээр нь 1913 оны 11 дүгээр сарын 5-нд Орос, Хятад хоёрын хамтран гарын үсэг зуралцсан Илтгэн гаргасан бичигийнхээ агуулгыг Монгол Улсын Засгийн газарт тулган хүлээлгэх гэж оролдсноор эх үүсвэр нь тавигдсан болой.

Иймээс Монголын Засгийн газарт Хятад, Орос улсуудын бүрэн эрхт төлөөлөгчдийг оролцуулсан гурван талын хэлэлцээрийн ширээний ард суухаас өөр арга зам байгаагүй юм. Өвөр Монгол, Хөлөн бойр, уриайнхайн асуудлыг энэ гурван этгээдийн хэлэлцээрээр огт хөндөхгүй хэмээн Сайн ноён ханыг Оросууд ятгаж чадсан байлаа. Ерөнхий консул А.Миллер Монголын төрийн зүтгэлтнүүдийн өөрийнхээ тусгаар тогтнолын талаар баримталж байсан бодлого, байр

⁴⁰ А.В.Бурдуков. Хуучин ба шинэ Монголд УБ., 1987..х.129

⁴¹ Кодамгийн Хүрээнд байсан тухай тэмдэглэл- Ц.Батбаяр Кодاما Мидуй пүүс, Хүрээнд байсан япончууд УБ., 1993 х.65-66

суурийг сайтар мэддэг нэгэн байсан юм. Тэрээр Орос хятадын 1913 оны тунхагийн талаар Монголын Засгийн газарт танилцуулсан тухайгаа Петербургт мэдээлэхдээ «миний энэ танилцуулга Ханд чинванд туйлын тааламжгүй сэтгэгдэл төрүүллээ. Монголын гадаад яамны сайд ингэж сэтгэл эвдэрсэн байхыг би анх удаа үзэв» гэж бичиж байжээ. 1913 оны 11 дүгээр сарын 3-нд Ханддорж Бээжингийн тунхагийн тухай Миллертэй ярилцахдаа: Хятад хэмжээт эзэрхлэл ёс төдий шинж чанартай ч атугай хятадуудад манай Монголыг дахин өөрийн муж болгон хувиргах нүх сүв гаргаж өгөх тул манай засгийн газар хэрхэвч үл зөвшөөрнө гэдгээ албан ёсоор хэлж байжээ.⁴² Иймээс А.Миллер Монголын төрийн баримталж байсан байр суурийг сайтар ойлгож байсан учраас монголчуудтай нилээд дотно байдлаар харьцаж байсан болно.

Энэ үеийн Монголын тусгаар тогтнол, бие даасан байдлын асуудал чухам ямар байсныг Оросын монгол судлаач В.Л.Котвичийн тодорхойлсноор үзэх аваас, тэрээр Монголын дотоод болон гадаад нөхцөл байдлыг нилээд бодитой мэдэрч байжээ хэмээн үзэж болох мэт. Котвич 1911 оны 12 сарын 30-ны өдөр Бурдуковт бичсэн захидалдаа: “Монголчууд өөрийн тусгаар тогтнолоо хадгалж, хамгаалж чадах эсэх талаар хэлэхэд тун хэцүү байна. Бүрэн хэмжээгээр бараг л үгүй болов уу. Хэрэв Орос орон бага зэрэг туслах аваас нэг хэсэг эрх олж авч чадах буй за. Гэвч Бээжингийн засгийн газраас бага хэмжээнд ч гэсэн хамаарч байх бололтой, үнэхээр хятадууд монголын дотоод хэрэгт оролцохгүй тохиолдолд шүү”⁴³ хэмээн бичиж байсан бол 1912 оны зун Монголд ирснийхээ дараа тэрээр: “Улс төрийн өөрчлөлт ард түмний амьдралд өөрчлөлт авчирсангүй. Маш ядуу, хүнд байдалд байна. Өөрийн тусгаар тогтнолоо тунхагласан боловч тэд харах хандах хүнгүй хүүхдүүд шиг л байна” хэмээн бичсэн байна. Оросын нэрт эрдэмтэн, монгол судлаач Б.Я.Владимирцов 1912 оны 6 сарын 25-нд Бурдуковт бичсэн захидалдаа: Орос орон Монголд юм хийх гээд байгаа мэт боловч үнэн хэрэг дээрээ гадаадын хүчнүүд, түүний дотор японы эсэргүүцлээс айгаад юу ч хийж чадахгүй байна гээд “Монгол орон Орос оронд, Сибирьт ямар их чухал хэрэгтэй болохыг Орост хэн ч ойлгохгүй байна. Монголын тухай мэддэг хүн ч байхгүй шүү дээ. Монгол чинь Манжуур биш гэдгийг ойлгохгүй. Гэвч сүүлийн үед аажмаар нийгмийн дунд ойлгож эхэлж байх шиг байна” гэжээ. Харин Монгол дахь Оросын ерөнхий консул А.Миллер Японы иргэн Кодама хэмээгч лүгээ 1913 оны 9 дүгээр сард уулзахдаа: монголын эрх баригчид нэг их сүрхий тусгаар тогтносон улсын дүр

⁴² БНМАУ-ын түүх Дэд боть УБ., 1968., 493 дахь тал

⁴³ А.В.Бурдуков. В старой и новой Монголии М., 1969., с.265

үзүүлж байна. Эднийг сэнхрүүлэх тун бэрхтэй байлаа гээд, Кодамагаас эднийг морь сургахтай адил уран чадвараараа ухааруулбал тань дээр биш үү гэж асуухад тэрбээр «Гадаад Монголын морьдыг тийм амархан сургахгүй шүү» гэж хэлж байжээ.⁴⁴ Энэ бол А.Миллер монголчуудтай харьцаж, тэдний зан заншилыг сайтар ойлгохтойгоо болсоны шинж юм.

Энэ үеийн Оросын Монголын талаар баримталж байсан бодлого нь 1907-1910, 1912 оны Орос-Японы Алс дорнод дахь нөлөөллийн бүс хуваах тухай нууц хэлэлцээрүүдийн агуулгаар тодорхойлогдож байлаа. Энэ үед Хятад улс хөгжлөөр Оросоос сул дорой байсан тул Оросын засгийн эрх баригчдын бодлого тухайлбал, Монголын асуудлаар илүү зонхилох үүрэгтэй байж, Монгол дахь ерөнхий консул Миллерт тэрхүү үүргийг хэрэгжүүлэх хариуцлага ногдсон байна. Тэрбээр эл үүргээ Оросын засгийн газрын бодлогод нийцтэйгээр хэрэгжүүлж чадсан нэгэн билээ.

Гурван улсын хэлэлцээр Оросын Хиагт хотноо болж, түүнд Хаант Оросын талаас Төлөөлөгчдийн тэргүүн: Хүрээнд суугаа Оросын төлөөний элчин бөгөөд ерөнхий консул Александр Миллер, гишүүд: Хиагтын хилийн комиссар Хитрово, Монгол дахь ерөнхий консулын дэргэдэх суурин төлөөлөгч Болобан нар оролцсон юм.

А.Миллер нар хэлэлцээрийн албан ёсны хуралдааны үеэр болон албан бус цагаар Монголын төлөөлөгчид лүгээ нэг бус удаа уулзаж, уг хэлэлцэж буй асуудлаар ямар тактик хэрэглэж болохыг зөвлөж байсан удаатай аж. Хэдийгээр Орос улсын эрх ашгийг хамгаалж тэмцэж байсан боловч нилээд асуудал дээр Монголын ашиг сонирхолд нийцтэй байр суурийг А.Миллер баримталж чадсан юм.

Хэлэлцээрийн явцад Хятадын төлөөлөгчдийн тэргүүн Би Гуй Фаны Монголын тусгаар тогтнолыг үл зөвшөөрөн, Монголын Хааны болон улсын цол, Олноо өргөгдсөн он тоолол зэргийг өөрчлөх явдлыг хэлэлцээрийн зайлшгүй нөхцөл болгон тавьж байсан хатуу болзол⁴⁵ Монголын төлөөлөгчдийн улсынхаа тусгаар тогтнолын төлөө хэмээсэн эргэлт буцалтгүй байр суурийг хооронд нь зуучлан зохицуулах хэцүү үүрэг А.Миллерт ногдсон юм. Тиймээс А.Миллер Монголын хааны цол, он тоолол зэргийг хэлэлцэх үеэр Марокко, Бухар, Египет зэрэг улсуудыг үлгэр жишээ болгон “эдгээр орнуудын эзэд нь хэдийгээр мөн орнууд нь хамгаалал дор байвч хуучин хэвээр сүлд, эмир, хан хэмээх цолуудыг хэрэглэсээр”⁴⁶ буйг тайлбарлаж байжээ. Үүнд Хятадын төлөөлөгч: “эдгээр үлгэрүүдийг Гадаад Монгол дор үл таармой” хэмээжээ. Чингэхэд Оросын элчин Миллерээс хоёр талын

⁴⁴ Кодамагийн Хүрээнд байсан тухай тэмдэглэл - 11.Батбаяр Кодама Мицуй пүүс, Хүрээнд байсан япончууд УБ., 1993 х.65-66

⁴⁵ Мөн тэнд 175 дахь тал

⁴⁶ Мөн тэнд. 189 дэх тал

дундыг баримтлан: “өөрөө эзэрхэх Монгол” хэмээн бичих санал гаргахад Монголын тал зөвшөөрч, харин Хятадын элчин нилээд уурсаж: “Би үхэвч бээр **Гадаад** хэмээх үсгийг хасаж чадахгүй”⁴⁷ гэж тас эерж хурлыг тарааж байсан нь хүртэл харагдана.

Хэлэлцэж буй асуудал хурцдаж, бүр зарим талаар хурал цааш үргэлжлэх боломжгүй шахам болсон үед А.Миллер уг асуудлаар байр сууриа илэрхийлэн “Хэрэв Хятад тохирохгүй буцваас хэмжээтэй эзэрхэх эрхийг ч алдагдах буй за. Монголын тухай өчүүхэн хэрэгт бидний хоёр улс найрамдлыг эвдэж яахин болмой. Харин ч Гадаад Монголыг олон улсын дунд ямар зэрэг дэвээр байхыг тодорхойлох нь манай Орос улс дор Хятадаас бага үгүй чухал болгон санагдмой. Нэгэнт Орос Хятад хоёрын илтгэн гаргах бичиг дор гарын үсэг зурсан тул үүгээр Оросоос Гадаад Монголын өөртөө эзэрхсэнийг хүлээсэн болмой”⁴⁸ гэж Хятадын төлөөлөгчдийн хатуу байр суурийг туршлагатай дипломат хүний арга ухаанаар зөөлрүүлж, хэлэлцээрийг гацаанаас гаргаж байсан удаатай ажээ. Ийнхүү Хятад, Монгол хоёрын төлөөлөгчид баахан маргалдаж, Оросын элчин дундыг барьж зуучилсны эцэст “Монголын Богд хааныг Гадаад Монголын маш арилсан Богд Жавзандамба хутагт хаан” хэмээхээр тогтсон (зөвхөн хаан хэмээх үгийг нотлохын тулд Түшээт ханы хуучин тамгыг Хүрээнээс авчруулж байжээ) ба мөн зөвхөн Хятад лугаа харилцах албан бичигт “Дундад Иргэн Улсын оны тоог хэргэлж, Монголын арван хоёр жил, сарны улирлыг хавсран бичих” ба Монгол улс дотор болон Орос лугаа харилцах бичиг үйлдэхэд улсын цол, Олноо өргөгдсөн хэмээх оныг хэвээр хэрэглэхээр “тохиролцжээ”. Энэ бүгд нь монголын төлөөлөгчдийн ихээхэн тэмцлийн бага боловч ололт байсан төдийгүй Оросын элчин төлөөлөгчдийн багагүй чармайлтын үр дүн байсан гэж үзэж болно.

Монголын төлөөлөгчдөөс Монголын засаг, улсын нэр, хааны нэрээ хамгаалж, Хятадын төлөөлөгчдийн өөрийн дангаар ноёрхох эрхийг бүрэн тогтооход чиглэсэн саналыг эрс эсэргүүцэн эсрэг тэсрэг байр сууринаасаа хөдлөхгүй байж, хэлэлцээр удаа дараа гацаанд орж байсан учраас Оросын төлөөлөгчдийн тэргүүн А. Миллер хэлэлцээрийг урагшлуулах үүднээс дипломат арга хэрэглэж, Богд хаанд захиа бичиж, Да лам Дашжавыг Ширнэндамдин, Ханддорж, Намнансүрэн нарын аль нэгээр солихыг санал болгож байжээ. Тиймээс ч нэг талаас 1914 оны 10 дугаар сарын 24-нд “Монголын төлөөлөгчдийн тэргүүн Дашжав миний хуучин өвчин хөдлөн хатамжих аргагүй тул чөлөө шагнана уу” хэмээн гуйсан тул Богд хааны зарлигаар

⁴⁷ Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (Өдөр тутмын тэмдэглэл)

Баримт бичгийн эмхтгэл УБ., 1999., 223 дахь тал

⁴⁸ Мөн тэнд , 205 дахь тал

Дашжавыг чөлөөлж, 1914 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс Бүрэн эрх барих элчин сайдад Шүүх таслах яамны дэд сайд Эрдэнэ жонон бэйс Ширнэндамдинг томилж байжээ.

Хаант Орос, Хятадын төлөөлөгчид, ялангуяа хятадын эрх баригч Монголыг “улс” хэмээн томьёолохыг эрс эсэргүүцэж, **“хэрэв улс хэмээн бичвээс Хятадаас салсан болох ба Орос улс залгихад хүрнэ”** хэмээн зүтгэн, гэрээний хятад, монгол үсгээр бичсэн хувь дор баримталбал зохих үндсэн франц үсгийн хувиас гажиж, Оросын төлөөлөгчдийн тэргүүн Миллер “Хэрэв миний үгийг эс зөвшөөрвөөс гэрээг Монгол үсэг үгүй батлан тогтоох буюу эсгүүл Орос, Хятад хоёр өөрчлөн хэлэлцэн тогтоож болмой. Тэр цаг дор үүнээс сайн болох буюу” гэхчилэнгээр Монголын төлөөлөгчдийг сүрдүүлэх оролдлого хийж байсан нь архивын эх сурвалжид тэмдэглэгдэн үлджээ.

Мөн Монголын засгийн хэрэг шийтгэх газрыг албаны газар өөртөө эзэрхсэнийг өөрөө засах хэмээн хятад үсгийн ёсоор бичвээс зохино гэж Хятад, Орос элчин дүрэмдэж, баахан маргалдсаны эцэст “Орос элчин Хятад лугаа өөр газар баахан хэлэлцээд Монгол үсэг дор засгийн хэрэг шийтгэх газрыг хэвээр бичсүгэй, хэмжээтэй эзэрхэх эрх ба өөртөө эзэрхсэн хэмээх үсгийг цөм франц улсын үсэгний аялгуугаар бичсүгэй” хэмээн тохиролцсон нь Монголын төлөөлөгчдийн хувьд Өөртөө эзэрхсэн Гадаад Монгол хэмээн үлдээх зөвшөөрөл олсон ихээхэн зүтгэлийн үр дүн байв. Энд Оросын төлөөлөгчдийн тэргүүн Миллерийн дипломат ухаан зарцуулсаны хүчинд Хятадууд зарим талаар буулт хийж байсаныг тэмдэглэх хэрэгтэй буй за.

Монгол Улсыг “Өөртөө эзэрхсэн Гадаад Монгол” хэмээн нэрлэхээр тогтсон төдийгүй бас хил хязгаарын асуудлыг хүртэл эл гэрээнд тусгасан байдаг. Уг гэрээний 11 дүгээр зүйлд: “Өөртөө эзэрхсэн Гадаад Монголын газар нь болбоос 1913 оны Октябрь сарын 23-ны өдөр Орос Хятадын солилцсон бичгийн 4 дүгээр зүйлийн ёсоор Хүрээний хятад амбан, Улиастайн жанжин, Ховдын хятад амбаны захиргаанд байсан газрууд бөгөөд Хятад лугаа нийлсэн хил нь Зүүн зүг Хөлөн бойрын хязгаар, Өмнө зүг Дотоод Монгол, Баруун өмнө Саян хаян мужийн хув, Баруун зүг Алтайн хязгаар лугаа зах нийлсэн халхын 4 аймаг ба Ховдын хязгаарын олон хошуудын хилээр баймой”⁴⁹ хэмээн заасан нь хожим 1945 онд Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлийн үеэр Англи, Америк, Орос гурван их гүрний тэргүүн нарын уулзалтаар “Гадаад Монголын статуског одоогийн байгаа хилээр хүлээн зөвшөөрөх” үндэс болсон бизээ. Хиагтын гэрээгээр Монголын Хятад лугаа нийлсэн хилийг нарийвчлан тогтоох асуудлыг гэрээ тогтоосноос хойш 2 жилийн дотор

⁴⁹ Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (Өдөр тутмын тэмдэглэл) Баримт бичгийн эмхтгэл УБ., 1999., 208 дахь тал

3 эгээдийн төлөөлөгчдийг оролцуулан шийдвэрлэхээр заасан ч талаар өнгөрсөн болохыг бид мэднэ.

Энэ бүхэн бол 1915 оны гэрээгээр Монгол улс оросын монголч эрдэмтийн нэрлэснээр «широкая автономия»⁵⁰ өргөн автономи эрхтэй улс байхыг хоёр хөршөөрөө хүлээн зөвшөөрүүлж чадсан хэрэг юм. Энэ нь нэг талаас олон улсын гэрээ ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн «улс» болсон бөгөөд 1911 оны дараах үеийн тунхаглал төдий тусгаар тогтнолоос нэг алхам урагш болсон хэрэг хэмээн үзэж болмоор санагддаг юм. Мөн тухайн үедээ гурван улсын гэрээгээр тогтоосон Монголын байдлыг Монголын төрийн зүтгэлтнүүд хэрхэн ойлгож байсаныг дараах баримтаас харж болно. Үүнд: “Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамнаас Богд хаанд айлтгасан “Дундад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарласан дэвтэр”-т өгүүлэхдээ: “хүчирхэг нь буурайгаа дарлан элдэв эрх ашгийг булаан эзэрхэхийг хичээх нь олон улс нийтэд бүхий далсан суртал мөн тул эс болгоомжилбоос эс болох... Энэхүү гэрээ бичгийн гол утга болбоос бидний улс хэдий Дундад улсын хэмжээтэй эзэрхэхийг хүлээсэн боловч Дундад улсаас бидний дотоод засгийн буй бүхий хэрэгт оролцох эрх огт үгүй...” хэмээн тэмдэглэсэн байна. Өөрөөр хэлбэл Монголын дотоод хэрэгт Хятад оролцохгүй гэсэн үг билээ. Энэ бол бие даасан улсын адилаар өөрийн дотоод бүхий л асуудлыг шийдвэрлэж болохыг орос, хятад хоёр хүлээн зөвшөөрсөн хэрэг юм.

Олон улсын жишигт хэрэглэж ирсэн уламжлал болон Монголын улсын тухайд хэрэглэсэн автономи, сюзеринетет хэмээх үгийн утга учирьг нягтлан үзэх аваас,

Автономи - Энэ үгийг Коростовец дангаараа Хятадтай хэлэлцэн тохирч, нөгөө талаар монголчуудыг мэхлэх зорилгоор гаргаж ирсэн үг хэмээн үзэх болов гэж Японы эрдэмтэн Танака Кацухико “Тусгаар тогтнол уу, автономи уу” бүтээлдээ⁵¹ бичжээ. Гадаад Монголын төлөөлөгчид “автономи” хэмээх үгийг амьдрал дээр хагас эрхтэй улсын хувьд хэрэглэдэг, “сюверенитет” хэмээх үгийг ямар ч дотоодын мужид хэрэглэдэггүй тул Гадаад Монгол нь өөрийн өвөрмөц байдлыг үндэслэн дотоодын бүх асуудлыг биеэ даан шийдэх эрхтэй гэж тайлбарлаж байжээ. “Автономит хэмээх үг нь Фа (Франц) улсын үг бөгөөд Дундад улсаас автономи хэмээх үгийг өөрөө засах хэмээн орчуулваас зохимой хэмээх ба Орос улсын төлөөлөгч (Миллер -О.Б) автономи хэмээх үсэг болбоос өөрөө эзэрхмой хэмээсэн утга буй хэмээн тайлбарлаж байсан бол бидний Монгол улс болбоос Автономит хэмээх үгийг өөрөө эзэрхэх хэмээн орчуулмой хэмээн

⁵⁰ Е.А.Белов, С.Г.Лузянин. О концепции «монгольского вопроса» в истории МНР, - журнал «Восток», 2000, No 1

⁵¹ Танака Кацухико Тусгаар тогтнол уу, автономи уу – Тусгаар тогтнолын мөрөөдөл (Япончууд Монголын тухай) УБ., 1991., 10 дахь тал

харилцан тэмцэлдэж эс тохирсон учир даруй уул Фа улсын үгний аялгаар бичсэн”⁵² хэмээжээ.

Харин **сюзеренитет** хэмээх үгийн тухайд “энэ үг язгуураас Франц хэлнээс гаралтай бөгөөд Дундад улсаас сюзеренитет хэмээх үгийг уг эзний эрх хэмээх ба Орос улсаас энэ нь цөм олон улс нийт дор хэрэглэж тогтсон үг, сюзеренитет хэмээх үсэг болбоос хэмжээтэй эзэрхмүй хэмээсэн утга буй хэмээх бөгөөд Бидний Монгол улс болбоос сюзеренитет хэмээх үгийг эрх үгүй хэмжээтэй эзэрхэх хэмээн орчуулмой хэмээн харилцан тэмцэлдэж эс тохирсон учир даруй уул Фа улсын үгний аялгаар бичсэн” хэмээн Магсар хурцын бичсэн “Монгол улсын шинэ түүхэнд”⁵³ бичжээ. Мөн Оросын дипломатуудын гаргасан сюзеренитет хэмээх энэ үгийн агуулгын тухай Оросын Гадаад явдлын яамны сайд Сазоновоос Хүрээнд суугаа ерөнхий консул Миллерт явуулсан захидалдаа: “Бидний зөвшөөрөн хүлээсэн, Хятадаас Монголын хувьд эдлэх сюзеренитет нь тэр хоёр улсын хоорондын зөвхөн цааз хуулийн холбоо бөгөөд учир нь тэд Монгол улс бүх асуудлын талаар, тэр ч байтугай улс төрийн талаар гадаадтай харилцах эрхийг үгүйсгэхгүй юм”⁵⁴ хэмээжээ. Миллер Оросын засгийн газрын энэ л чиглэлийг ягштал баримталж байсан юм. Харин “Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамнаас Богд хаанд айлтгасан “Дундад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарласан дэвтэр”-т энэ талаар өгүүлэхдээ: “Гадаад Монгол Дундад улсын сюзеренитетийг хүлээн зөвшөөрснөөр улс төрийн байдлаа алдсан явдал огт үгүй. Харин ч Дундад, Орос хоёр улстай хамт нийлэн зөвхөн хэлэлцэх чухал эрхийг олж авсан энэхүү гэрээ бичгийг төгсгөж байгуулаад олон улсын дунд өөрийн дотоод засгийн бүх хэрэг зүйлийг өөртөө эзэрхэх улс төр болсноо илэрхийлжээ” хэмээсэн байна. Энэ бүхэн бол Монголын улс байх эрхийг орос, хятадын төлөөлөгчид эл гурван этгээдийн гэрээ хэлэлцээрээр бүр мөсөн хориглож чадаагүй болох нь харагдаж байгаа юм. Үүнд мэдээж Монголын тухайн үеийн төрийн зүтгэлтнүүдийн нөр их ухаан, хүчин чармайлт, мятаршгүй тэмцэл, олон зууны турш үеэс үе дамжин ирсэн залгамж чанар хадгалсан түүхэн уламжлалаа өвлүүлэх чин эрмэлзэл нөлөөлсөнийг тэмдэглэхээс гадна 1911 оны үндэсний хувьсгалын үеэс Монголыг дэмжиж ирсэн цорын ганц орон болох Хаант Оросын засгийн газрын бодлого, түүний төлөөлөгч А. Миллерийн ихээхэн хүчин зүтгэлийн үр дүн байсаныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Иймээс ч гурван улсын хэлэлцээрийн төгсгөлд Монголын төлөөлөгчдийн тэргүүн Ширнэндамдин, Чагдаржав нарын санал болгосоны дагуу Богд Хааны зарлигаар

⁵² Магсаржав Н. Монгол Улсын шинэ түүх., УБ., 1994 он. 102 дахь тал

⁵³ Н.Магсаржав Монгол Улсын шинэ түүх, УБ.,1994 он, 102 дахь талыг үзнэ үү.

⁵⁴ Сборник дипломатических документов по Монгольскому вопросу., Санкт-Петербург, 1913 г., с.90

Оросын төлөөлөгчдийн тэргүүн элчин сайд А. Миллерт чин вангийн эрдэнийн очир, түүний орчуулагч түшмэл Авдаевт түшээ гүнгийн эрдэнийн очир шагнан хөхүүлсэн байдаг.⁵⁵

Эндээс үзвэл Монгол улсын хувьд гурван улсын гэрээ зарим талаар эерэг үр дүн өгсөн хэмээхийг тэмдэглэвэл зохино. Харин зарим монголч эрдэмтдийн нэрлээд байгаа тэрхүү өргөн автономи нь манай төрийн зүтгэлтнүүдийн тухайн үедээ тайлбарласантай дүйцэх ойлголт байхыг үгүйсгэхгүй юм. Мөн түүнчлэн эл гурван улсын гэрээгээр Хятадын сюзеренитет бүхий автономит Монгол нь өөрийн нутагт хятад цэрэг оруулахгүй, өөрийн үндэсний засгийн газар, цэрэг армитай байх эрх авсан юм. Харин эл гэрээ ёсоор Орос улс эдийн засгийн талаар болон улс төрийн талаар Монголд Хятадаас давуу эрх эдлэх болсон юм. Иймээс 1915 оны Хиагтын гэрээгээр Монгол орон Оросын тал руу эргэх замдаа орсон юм. Иймээс энэ үеийн Хаант Оросоос Монголд явуулсан бодлогыг «Монголыг яах аргагүй ивээн тэтгэж хамгаалалдаа авах» бодлого хэмээн нэрт монголч эрдэмтэн О.Латимор тэмдэглэсэн байна.⁵⁶ Энэ бол өөрийн тусгаар тогтнолоо цаашид бүрэн утгаар нь олж авах, Монгол төрөө сэргээн мандуулах тэмцлийн нэгэн хэлбэр болсон хэмээн үзэж байна.

Ийнхүү гурван этгээдийн хэлэлцээр бүтэн есөн сар үргэлжилсний дараа Монгол улсын Олноо Өргөгдсөний тавдугаар он буюу хөхөгчин туулай жил зуны тэргүүн сарын 25-ны нохой цагт Европын 1915 оны тавдугаар сарын 25-нд Хятад улсыг төлөөлж Би Гуй Фан, Чень Лу, Хаант Оросыг төлөөлж А.Миллер, Гадаад Монголыг төлөөлж Ширнэндамдин, Чагдаржав нар гарын үсэг зурж, 3 этгээдийн гэрээг⁵⁷ батлан тогтоогоод бичиг зүйлсийг солилцон эл хэргийг дуусгасан байна. 1913 оны Орос Хятадын хэлэлцээрийг үндэс болгосон энэхүү гурван этгээдийн гэрээгээр Богд хааны засгийн газарт Хятадын сюзеренитет эрхтэй автономит засгийг албан ёсоор тулган хүлээлгэсэн нь энэ бүлгөө.

Гурван улсын хэлэлцээр тогтоосноос хойш ч 1912 онд Орос, Монголын засгийн газрын хооронд байгуулсан Найрамдлын гэрээ хүчин төгөлдөр байх болно хэмээн А. Миллер Монголын төлөөлөгчдийн тэргүүн Ширнэндамдин, Чагдаржав нар лугаа сэм бичиг солилцон тохиролцсон байдаг билээ. Энэ нь Оросоос Монголын талаар баримталж ирсэн бодлого өөрчлөгдөхгүй гэсний илрэл байсан болно.

Түүхэнд улс хооронд болсон хурал дотроос хугацааны хувьд

⁵⁵ Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (Өдөр тутмын тэмдэглэл) Эмхтгэсэн О.Батсайхан, УБ., 1999., 291 дэх тал

⁵⁶ О.Латимор Нүүдэлчид ба хувьсгалчид УБ., 1994., 45 дахь тал

⁵⁷ Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (Өдөр тутмын тэмдэглэл) Баримт бичгийн эмхтгэл О.Батсайханы эмхтгэсэн УБ., 1999., 538 дахь тал

хамгийн удаан үргэлжилсэн Венийн бага хурлын (яг нэгэн зууны өмнө болсон) Азийн хувилбар болсон эл Гурван улсын Хиагтын хэлэлцээр нь урьд нь улс төрийн шалтгаанаар түүний эерэг, сөрөг тал тэр бүр судлаач, өргөн олон түмэнд хүрч бодит байдлаар дүгнэгдээгүй шахам байсан бөгөөд өчүүхэн молхи судлаач өөрийн судалгаандаа түшиглэн дараах дүгнэлтүүдийг хийхийг оролдлоо. Үүнд:

-Хиагтын эл хэлэлцээрт Монгол улс Орос, Хятадын нэгэн адил олон улсын тогтсон хууль ёсны дагуу бүрэн эрх бүхий нэгэн субъект нь байж, хэлэлцээрийн турш өөрийн улсын төлөөлөл, байр суурийг хамгаалж чадсан болохыг түүхэнд тэмдэглэх нь зүйтэй мэт санагдана.

-Эл хэлэлцээр Монгол улсыг ар, өвөр болгон хувааж, газар нутгийн хувьд Өвөр Монголыг Монгол улсын гал голомтоос нь хуульчлан тусгаарласан эрх зүйн баримт болсон юм. Хэдийгээр Хятадууд энэ үеэс хойшхи Монголыг Ар Монгол, Гадаад Монгол хэмээн бичиж, хэлж байгаа хэдий ч Монгол улсын тулгуур төрийн үндэс тэрхүү хэсэгт хадгалагдан үлдсэн юм. Харин Гадаад Монгол хэмээх нэрийн тухайд бол “Манж нар хятадыг өөрийн нутаг дэвсгэр гэж үзэж, Монголыг гадаад дахин, гадаад муж гэж үзэж байсанаас үүдэж “Гадаад Монгол” хэмээх улс төрийн нэр томьёо анхнаас Цагаан хэрмийн арын бүх монгол овогтныг ар, өвөр гэж ялгахгүй хамарч байсан байна. “Гадаад Монгол” хэмээх үг нийт Монгол гэсэн утгаар хэрэглэгдэж байжээ”⁵⁸ гэж эрдэмтэн Ш.Сандаг тэмдэглэсэн буй.

Гадаад Монголын төрийг засах явдлын яам хэмээх нэртэй байгууллага Манжийн үед Монголыг шууд захирч байсан төрийн захиргааны дээд байгууллага байсан нь Гадаад Монгол хэмээх нэрийн дор нийт монголчуудыг хамруулж байсаны илэрхийлэл юм. Харин ХХ зууны эхэн үеэс “Гадаад Монгол” хэмээх нэр томьёог Манж, Хятадын эрхтнүүд улс төрийн үүднээс агуулгаар нь өөрчлөн, зөвхөн халхын 4 аймаг, Ховдын хязгаарыг оруулсан байдаг бөгөөд Гурван этгээдийн хэлэлцээрт мөн л ийм утгаар хэрэглэгдэж, ийнхүү хуульчлагдсан нь тэр болой.

-Ийнхүү Монголыг ар, өвөр болгон хувааснаас үүдэж (энэ тухай Хятадын төлөөлөгчдийн тэргүүн хэлэлцээрийн үеэр удаа дараа Оросууд Ар Монголыг манайхаас салгаж байна хэмээн хэлж байжээ) хил хязгаарын асуудал гарч ирсэн бөгөөд 1915 оны Хиагтын эл хэлэлцээрээр ХХ зууны Монгол улсын хил хязгаарын асуудлыг үндсэнд нь тогтоож өгсөн нь хожим 1945 оны гурван гүрний Ялтын хурлаар Монголын статүскво тогтооход үндэслэл болж өгсөн болно.

-1915 оны энэхүү гэрээ нь Монгол улсын хувьд урд хөршөөсөө салан тусгаарлах 1911 онд эхэлсэн үйл явцаа улам бэхжүүлэх алхам

⁵⁸ “Монголын улс төрийн гадаад харилцаа 1850-1919” УБ.,1971 он. 32-33 дахь тал

болсон бөгөөд харин ч олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх эхлэл болсон хэмээн үзүүштэй. Хэдийгээр гэрээнд Монгол нь Хятадын нэгэн хэсэг болохыг ёс төдий заасан боловч эдийн засаг, улс төрийн эрх ашгийн хуваарилалт Оросын талд давуутай шийдвэрлэгдсэнийг олон зүйлээр харж болно. Үүнд элчин А. Миллер зохих үүрэг гүйцэтгэсэн нь дамжиггүй билээ.

- Хиагтын эл хэлэлцээр нь үндсэндээ Орос-Японы удаа дараагийн нууц гэрээ, хэлэлцээрийн агуулгаар тодорхойлогдсон бөгөөд иймээс ч тухайлбал 1912 оны 6 сарын 25-нд Орос, Япон хоёр улсын байгуулсан нууц гэрээнд заагдсан Орос, Японы тусгай ашиг сонирхлыг зөрчихгүй байх үүргээ хэрэгжүүлсэн хэмээн үзэж болох юм.